



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2006 оны 05 сарын 04-ний өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ,
Ёс зүйн хорооны дүрэм, журам
батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ НЬ:

1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг нэгдүгээр, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны дүрмийг хоёрдугаар, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороодын үлгэрчилсэн журмыг гуравдугаар, мэс засал/мэс ажилбар хийлгэх тухай зөвшөөрлийн хуудсийг дөрөвдүгээр, амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийн хуудсыг тавдугаар, өөрийн хүсэлтээр эмнэлгээс гарах зөвшөөрлийн хуудсыг зургаадугаар, тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай хуудсыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг улсын хэмжээнд сурталчилах, мөрдүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны дарга (Б. Батсэрээдэнэ), Төрийн захиргааны удирдлагын газар (Б. Баярт)-т тус тус үүрэг болгосугай.
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороодыг байгуулж, эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд ёс зүйн хэм хэмжээг сурталчилах, мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг нийт эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Б. Батсэрээдэнэ)-д даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2002 оны 172 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

Л. ГҮНДАЛАЙ

Нэр томъёоны тайлбар

Энэхүү эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээнд хэрэглэгдсэн зарим нэр томъёог дараахь байдлаар ойлгоно:

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” гэж эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой итгэл үнэмшил, чиг хандлага, зан үйл, дадал, тогтсон дэг жаяг, хэвшсэн соёл болон харилцааны тухай цогц ойлголтыг;

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” гэж эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг;

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн горим” гэж эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмуудыг;

“Эмнэлгийн мэргэжилтэн” гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.7 заалтын дагуу;

“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.3, 3.1.5 заалтын тодорхойлолтуудыг нэгтгэсэн ойлголтыг;

“Эрүүл мэндийн байгууллага” гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.6 заалтын дагуу;

“Эмнэлгийн яаралтай тусламж” гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.10 заалтын дагуу;

“Биологийн идэвхит бүтээгдэхүүн” гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.21 заалтын дагуу;

“Үйлчлүүлэгч” гэж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахтай холбоотой харилцаанд оролцогч иргэнийг;

“Үйлчлүүлэгчийн нууц” гэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн яриа, өвчний түүх, үзлэг, шинжилгээ, өвчний хэтийн байдалд үнэлгээ өгсөн тэмдэглэл зэргээс олж авсан “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 4.1.2; 4.2.2-т заасан мэдээ, баримт бичиг, биет зүйлийг;

Хөндлөнгийн саадгүй орчин гэж үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байх үед хөндлөнгийн хүн (бусад эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч) саад болохооргүй өрөө тасалгаа эсвэл зориулалтын хаалтаар тусгаарлагдсан өрөө тасалгаанд тусламж үйлчилгээ үзүүлэхийг.

“Давхар харилцаа” гэж эмч-үйлчлүүлэгчийн харилцаанаас гадуур бусад харилцаа тухайлбал өөрийн үйлчлүүлэгчтэй бэлгийн харилцаанд орох; тэднийг өөрийн эрхшээлд оруулах зэргээр хувийн харилцаанд орохыг (ийм харилцаа нь эмнэлгийн мэргэжилтэн-үйлчлүүлэгчийн харилцааны зорилгыг алдагдуулах, үйлчлүүлэгчийн эмзэг байдлыг ашиглах, үйлчлүүлэгчид үзүүлэх эмнэлгийн тусламжийн талаарх бодит шийдвэрийг тодорхойгүй болгох, үүгээрээ үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд хохирол учруулж болох талтай тул ёс зүйг ноцтой зөрчиж буй асуудал болно).

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү ёс зүйн хэм хэмжээг эмнэлгийн бүх мэргэжилтэн мөрдөх бөгөөд мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн өвөрмөц хэм хэмжээг тухайн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нийгэмлэгүүд нэмэлтээр тогтоож, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан мөрдүүлнэ.
- 1.2 Ёс зүйн хэм хэмжээ нь Монгол улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай, бусад холбогдох хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон энэхүү ёс зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно.

Хоёр. Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээ

- 2.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төгс үзүүлэхэд өөрийн мэдлэг, чадвар, туршлагыг бүрэн зориулж ажиллана.
- 2.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна эрүүл мэндийн байдал, бэлгийн сонирхолоор нь үл ялгаварлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.
- 2.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн эрх ашиг, нэр төрийг дээдлэн хүндэтгэж, хүнлэг энэрэнгүй, шударга хандана.
- 2.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийнхээ үндсэн эрхийг хүндэтгэхийн зэрэгцээ хуулийн хязгаарлалтын хүрээнд үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгална.
- 2.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил нэгт нөхөд, эмнэлгийн бусад мэргэжилтний эрхийг хүндэтгэн, нөхөрсөг, шударгаар харилцан мэргэжлийн ур чадвар, харилцааны доголдол гаргах, хууран мэхлэх, залилахтай эвлэрэхгүй байхын зэрэгцээ эдгээр үйлдлээс өөрийгөө болон мэргэжил нэгтнээ сэргийлэн ажиллана.
- 2.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэн, шаардлагатай үед эрүүл мэндийн болон бусад мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, тэдэнтэй мэдлэг, ур чадвараа харилцан солилцож, шинжлэх ухааны ололт, нээлтийг ажилдаа бүтээлчээр нэвтрүүлэхийг эрмэлзэж ажиллана.
- 2.7 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч, мэргэжил нэгт нөхөд, олон нийтийг холбогдох бодит мэдээллээр хангана.
- 2.8 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэдлэг, ур чадвараа хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй.
- 2.9 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн биеийн байдлыг сайжруулах, зовлон зүдгүүрийг багасгах, хөнгөлөх, түүнд сэтгэл санааны дэм үзүүлэхийг эрмэлзэж ажиллана.
- 2.10 Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн яаралтай тусламжаас бусад тохиолдолд хэнтэй хамтарч ажиллах, ямар орчин, нөхцөлд тусламж үзүүлэхээ өөрөө шийдэх эрхтэй.
- 2.11 Эмнэлгийн мэргэжилтэний дагаж мөрдөж буй хууль, тогтоол, дүрэм, журам нь үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэхгүй тохиолдолд түүнийг өөрчлүүлэх тухай саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавина.

2.12 Эмнэлгийн мэргэжилтэн нь биоанагаахын ёс зүйн талаар олон улс болон өөрийн орны холбогдох байгууллагуудаас баталсан хууль тогтоомж, дүрэм, журам, зөвлөмжүүдийг мөрдөнө.

2.13 Эмнэлгийн мэргэжилтэн нь аливаа дүгнэлт, шийдвэрийг бодит байдалд тулгуурлан үнэн зөв гаргана.

Гурав. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах горим

3.1 Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн харилцаа нь тэдний харилцан итгэлцэл, хүндэтгэл дээр тулгуурлах бөгөөд энэхүү харилцаанд аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл байх ёсгүй.

3.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл мэндийн байгууллага, эмчээ сонгох эрхээ эдэлж, сонголт хийхэд нь шууд нөлөө үзүүлэхгүй.

3.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ тухайн өвчин эмгэгийн мөн чанар, шалтгаан, оношлогоо, эмчилгээний аргууд, тэдгээрийн үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар болон бусад шаардлагатай үнэн зөв мэдээллийг үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-д энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлан, шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.

3.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн өвчний онош, тавилангийн талаар өөрт нь үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Амьдралын төгсгөлийн шатанд орсон буюу эдгэрэшгүй, тавилан тодорхойгүй өвчтэй үйлчлүүлэгчийн хувьд сэтгэл зүйн бэлтгэлээс хамаарч мэдээллийг хэдийд, ямар байдлаар бүрэн өгөхийг эмч шийднэ.

3.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхийн өмнө үйлчлүүлэгчээс дараахь тохиолдолд шийдвэрийг бичгээр авна:

3.5.1 Тусламж үйлчилгээнээс үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) татгалзсан;

3.5.2 Амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй тусламж үйлчилгээ үзүүлэх;

3.5.3 Мэс ажилбар, мэс засал хийх тохиолдол бүрт;

3.5.4 Үр хөндөлт хийх (насанд хүрээгүй охидод үр хөндөлт хийх бол эцэг/эхийн зөвшөөрлийг авна);

3.5.5 Донорын эд, эрхтэн шилжүүлэн суулгах ажилбар хийх (реципиент ба донороос тус тусад нь зөвшөөрөл авна)

3.6 Хэрэв үйлчлүүлэгч насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй бол шийдвэрийг түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-өөс бичгээр авна.

3.7 Эмнэлгийн мэргэжилтэн нь дараахь тохиолдолд үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүй эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргаж болно:

3.7.1 Үйлчлүүлэгч сэтгэцийн хувьд чадамжгүйгээс зөвшөөрөл өгөх боломжгүй үед яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхгүй байх нь ноцтой үр дагаварт хүргэх нь илэрхий;

3.7.2 Өвчний талаарх мэдээлэл нь үйлчлүүлэгчид сэтгэл зүйн хүнд цохилт өгөх, түүнээс үүдсэн ноцтой үр дагавар учруулах эрсдэлтэй;

- 3.8 Эмнэлгийн мэргэжилтэн нь нэр төрөө хамгаалах, ашиг орлогоо нэмэгдүүлэх үүднээс тусламж үйлчилгээний тодорхой хувилбарыг үйлчлүүлэгчид тулгаж болохгүй ба өөрийн болон байгууллагын чадавхийг бодитой үнэлэн, сонголт хийх боломжтой бусад хувилбаруудын талаар үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, санал болгох үүрэгтэй.
- 3.9 Эмнэлгийн мэргэжилтний үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээ нь түүний биеийн байдлыг сайжруулахад чиглэсэн оновчтой, аливаа нэмэлт, зовиур шаналгаа үүсгэхгүй байвал зохино.
- 3.10 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн шаардсан тусламж үйлчилгээг нотолгоо, үндэслэлгүй гэж үзвэл татгалзаж болно.
- 3.11 Эмнэлгийн мэргэжилтэн нь тухайн нөхцөлд заавал хийгдэх шаардлагагүй тусламж үйлчилгээг зааварчлах, үзүүлэх нь ёс зүйд үл нийцнэ.
- 3.12 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн дэргэд биеэ авч явах соёлыг эзэмшсэн байвал зохино. Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтний биеэ авч явах соёлын талаар журам гарган, мөрдүүлнэ.
- 3.13 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчтэй холбоотой мэдээллийн нууцыг “Хувь хүний нууцын тухай хууль”-ийн 6-р зүйлд зааснаас бусад тохиолдолд түүнийг амьд сэрүүн байх хугацаанд төдийгүй нас барсных нь дараа ч чандлан хадгална.
- 3.14 Эмнэлгийн мэргэжилтэн нь өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бусад бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу бусдад ашиглуулахаар хувиран өгч болохгүй.
- 3.15 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил, албан тушаалын давуу талаа ашиглан өөрийн үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч), найз нөхөдтэй мэргэжлийн харилцаанаас гадуур харилцаа (давхар харилцаа)-нд орж үл болно.
- 3.16 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийг бүрэн гүйцэд, нягт нямбай үзэж оношлох ба эмнэлгийн холбогдох бичиг баримтыг цаг тухайд нь үнэн зөв хөтлөх үүрэгтэй. Бичиг баримтыг нөхөж бичих, засварлах, устгах, хуудас сольж үл болно.
- 3.17 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг хөндлөнгийн саадгүй орчинд үзүүлнэ.
- 3.18 Үйлчлүүлэгч эмнэлгийн мэргэжилтэн, түүний мэргэжил нэгт нөхдөд хүндэтгэлгүй хандах, ёс бусаар харилцах зэрэг шалтгааны улмаас мэргэжлийн харилцаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй байдал үүсвэл эмнэлгийн мэргэжилтэн түүнд тусламж, үйлчилгээ үргэлжлүүлэн үзүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн татгалзах болсон үндэслэлээ үйлчлүүлэгчид хэлж, өөрийн байгууллагын удирдлагад бичгээр

мэдэгдэх бөгөөд дараагийн эмнэлгийн мэргэжилтэн тусламж үйлчилгээг бүрэн хариуцан авах хүртэл үүрэгт ажлаа үргэлжлүүлнэ. Эмнэлгийн мэргэжилтэн нь хариуцлагаас зайлсхийх зорилгоор ийм үйлдэл хийж болохгүй.

- 3.19 Эмнэлгийн мэргэжилтэн нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн түүнийг зөрчигдөхөөс сэргийлж, үйлчлүүлэгчийн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр анагаах болон шинжлэх ухааны туршилтанд хамруулж үл болно.
- 3.20 Эмнэлгийн мэргэжилтний хувьд шинжлэх ухааны үндэслэлгүй эмчилгээ хийх, түүнийг дэмжин оролцох нь ёс зүйд үл нийцнэ.
- 3.21 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчээс шан харамж, албан бус төлбөр авч болохгүй.

Дөрөв. Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцааны горим

- 4.1 Эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа нь нэг нэгнийгээ дэмжсэн, харилцан хүндэтгэсэн, хамтын ажиллагааны зарчимд үндэслэнэ.
- 4.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна эрүүл мэндийн байдал, бэлгийн сонирхолоор нь мэргэжил нэгтнээ ялгаварлан гадуурхахгүй, тэгш шударга харилцана.
- 4.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил нэгтэн болон эрүүл мэндийн бусад ажилтнуудыг харилцааны доголдол, ёс зүйгүй үйлдлээс сэргийлж, алдаа дутагдлыг нь шударгаар илчлэн, засаж залруулахад идэвхитэй оролцоно.
- 4.4 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах зорилгоор эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжил нэгт нөхөдтэйгөө чөлөөт, шударгаар өрсөлдөхийг эрхэмлэнэ.
- 4.5 Эмнэлгийн мэргэжилтнүүд өөрсдийн мэдлэг, чадвар, туршлагаа мэргэжил нэгт нөхөдтэйгээ харамгүй хуваалцаж, харилцан бие биенээ сургах, хөгжүүлэх үүрэгтэй.
- 4.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн байгууллага, эмнэлгийн бусад мэргэжилтний нэр төр, мэргэжлийн ур чадвар болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст болон тэдний дэргэд дэлгэн ярих, шүүмжлэн хэлэлцэх нь ёс зүйд үл нийцнэ.
- 4.7 Эмнэлгийн мэргэжилтэн нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ өөрийн санаачлагаар буюу үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн хүсэлтээр бусад эмчийн зөвлөгөө, тусламжийг авч болно.
- 4.8 Хэвтэн эмчлүүлэгчдэд яаралтай тусламж үзүүлэхээс бусад тохиолдолд эмчлэгч эмчийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр эмч үзлэг хийх, тусламж үйлчилгээтэй холбоотой зааварчилга өгөх нь ёс зүйд үл нийцнэ.

- 4.9 Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар шийдвэр гаргах үйл явцад эмч нарын хооронд санал зөрөөтэй байдал үүсвэл эцсийн шийдвэрийг үйлчлүүлэгчийг гардан хариуцаж буй эмнэлгийн мэргэжилтэн гаргана. Эмч нарын зөвлөгөөн хийсэн тохиолдолд зөвлөгөөний шийдвэрийг дагана.
- 4.10 Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн талаарх өөрт байгаа бүх мэдээллийг дараах эмнэлгийн мэргэжилтнүүдэд саадгүй өгч болох ба үүний тулд үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-өөс зөвшөөрөл авах шаардлагагүй:
- 1) өөрийг нь шууд удирдан ажилладаг эмнэлгийн мэргэжилтэн
 - 2) зөвлөх мэргэжилтэн
 - 3) тухайн үйлчлүүлэгчийн эмчилгээний асуудлыг шийдэхэд шууд оролцож буй эмнэлгийн бусад мэргэжилтнүүд
 - 4) хуулиар олгогдсон эрх бүхий бусад хүмүүс
- 4.12 Яаралтай тусламж шаардагдсан үед үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нэгэн зэрэг хэд хэдэн эмч дуудаж, ирсэн тохиолдолд хэн нэгнээр нь үйлчлүүлэх талаар онцлон хүсэлт гаргаагүй бол түрүүлж ирсэн эмч дараагийн мэргэжилтэнд шилжүүлэх хүртэл тусламж үзүүлнэ.
- 4.13 Сувилагч нь эмчийн заавраар сувилахуйн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй хэдий ч анагаах ухаан, сувилахуйн стандартаас гажсан үйлчилгээ, үйлдлийг түүний зааврын дагуу гүйцэтгэх ёсгүй бөгөөд хэрэв ийм үйлчилгээ, үйлдэл хийхийг шаардсан, зааварласан тохиолдолд харъяалах албан тушаалтанд мэдээлнэ.

Удирдах ажилтан

- 4.14 Удирдах ажилтан нь эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэхээс өөр ажил эрхлэх болсноор эмнэлгийн мэргэжилтний хувьд хүлээх ёс зүйн үүрэг хариуцлага нь өөрчлөгдөхгүй.
- 4.15 Удирдах ажилтан нь албан тушаалын бүрэн эрхээ ашиглан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үйлчлүүлэгч, хамт олон, нийгэмд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бусдыг оролцохыг дэмжих ёсгүй.
- 4.16 Удирдах ажилтан нь эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс оролцох, зааварчлах, тулган шаардах ёсгүй.
- 4.17 Удирдах ажилтан нь мэргэжилтнүүдийн ёс зүйтэй холбоотой аливаа маргаантай асуудлыг дангаараа шийдвэрлэхгүй.
- 4.18 Удирдах ажилтан нь хариуцсан нэгж, байгууллагын түвшинд үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

ТАВ. Эмнэлгийн мэргэжилтэн нийгэмтэй харилцах горим

- 5.1 Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол Улсын Үндсэн хууль болон эрүүл мэндийн тухай хууль тогтоомжууд, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлж, хүн амын эрүүл

мэндийг дэмжих, хамгаалах талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, өрх бүл, иргэдтэй хамтран ажиллана.

- 5.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь өмчийн ямар ч хэлбэрийн байгууллагад ажиллаж байгаагаас үл хамааран өөрийн хувийн ашиг сонирголоос нийгэм, олон нийтийн эрх ашгийг илүүд үзнэ.
- 5.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь олон улсын болон халамж, буяны байгууллагууд, сайн санаат иргэдээс эмнэлгийн тусламж үйлчилгээнд зориулан өгсөн тусламжийг /хэлбэр үл хамааран/ зориулалтаар нь ашиглахыг эрхэмлэнэ.
- 5.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд хүнлэг энэрэнгүй хандан, тэднийг тарчлаан зовоох, харгис хэрцгий харилцах, доромжлох, басамжлах аливаа хэлбэрийг эсэргүүцэх ба өөрөө оролцох ёсгүй. Эмнэлгийн мэргэжилтэн нь ял эдэлж буй хүнд шүүхийн шийдвэрээс үл хамааран, харин батлагдсан оношийг үндэслэн стандартын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 5.5 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч мэс засал хийлгэсэн, эсвэл эмнэлэгт нас барсан тохиолдолд өөрийнх нь болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүний эд эрхтнийг авах, зарах, бүрэн бүтэн байдлыг алдагдуулах үйл ажиллагаа хийх, оролцох, энэ талаар зааварчилга өгөх ёсгүй.
- 5.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, интернэт, телефон утас бусад дам харилцааны хэлбэрээр дамжуулан нийтэд зөвлөгөө өгч буй тохиолдолд эмчилгээ оношлогооны аргыг шууд зааварчлахгүй. Харин тухайн өвчний талаарх ерөнхий мэдээлэл, тусламж үйлчилгээг авахад шаардлагатай лавлагаагаар хангаж болно.

ЗУРГАА. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн өвөрмөц асуудлууд

Сурталчилгаа

- 6.1 Эмнэлгийн мэргэжилтэн өөрийн үйл ажиллагааг сурталчилж болно. Сурталчилгаа нь зөвхөн эмнэлгийн мэргэжилтний мэргэжил эзэмшсэн сургууль, зэрэг цол, ажлын дадлага туршлага, үйл ажиллагаа явуулдаг байршил, тусламж үйлчилгээ үзүүлэх хуваарьтай холбоотой үнэн зөв мэдээллийг агуулах ба эмнэлгийн нэр томъёо хэрэглэхгүйгээр энгийн, ойлгомжтой үг хэллэг ашиглана. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийг илт төөрөгдүүлж, худал ташаа мэдээлэл бүхий сурталчилгаа явуулж болохгүй.
- 6.2 Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, үр дүн нь тодорхойгүй, стандартын бус, чанарын баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг дэмжиж сурталчлах, түүнийг оношлогоо эмчилгээнд хэрэглэх, зарж борлуулах, түгээх ёсгүй.
- 6.3 Эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний болон оношлогоо, эмчилгээний бусад аргатай холбоотой ташаа, бүрэн бус, ойлгомжгүй, хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас

баталсан дүрэм, журам, удирдамжаас гажсан мэдээлэл бүхий сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой.

- 6.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүний борлуулалтын ашиг, үйлчилгээний төлбөрөөс хувь хүртэх зорилгоор тухайн бүтээгдэхүүн ба үйлчилгээг үйлчлүүлэгчид санал болгож, сурталчлах нь ёс зүйд үл нийцэнэ.
- 6.5 Үйлчлүүлэгчийг өөрийн зөвшөөрөлгүйгээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танигдахуйц байдлаар харуулах буюу бусад хэлбэрээр сурталчилгаанд оруулах нь зохисгүй.

Тодорхойлолт гаргах, бичиг баримтад гарын үсэг зурах

- 6.6 Эмнэлгийн мэргэжилтэн нь бусдын хүсэлтээр ямар нэг тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах ёсгүй.

Эмнэлгийн нөөцийг хуваарилах

- 6.7 Эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхдээ яаралтай тусламжаас бусад тохиолдолд эхэнд ирсэн нь эхэлж үйлчлүүлэх буюу тэгш эрхийг хангасан хуваарилалтын зарчмыг баримтална.
- 6.8 Шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалд бодит үнэлгээ өгч, тогтсон журмын дагуу тусгай шалгууруудыг баримтлах ба шийдвэрийг эмчлэгч эмч бие даан гаргахгүй. Журам, шалгуурыг байгууллага бүр тогтооно.

Эмнэлгийн мэргэжилтэн ба хувийн эмнэлэг

- 6.9 Үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байхад эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн ашиг сонирхлын үүднээс өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадах нь ёс зүйд үл нийцэнэ.
- 6.10 Хэрвээ зайлшгүй шаардлагаар өөрийн хувийн өмчийн эсвэл үйл ажиллагааны ашгаас нь хувь хүртдэг эмнэлгийн байгууллагадаа үйлчлүүлэгчийг илгээвэл хувь хүртдэг тухайгаа үйлчлүүлэгчид мэдээлэхийн зэрэгцээ ижил төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бусад мэргэжилтэн, байгууллагын талаар бүрэн мэдээлэл өгөх нь ёс зүйд нийцэнэ.

Амьдралын төгсгөлд үзүүлэх тусламж, үйлчилгээ

- 6.11 Үйлчлүүлэгчийн амьдрах хугацааг уртасгахад чиглэсэн арга хэмжээ цаашид үр дүнгүй нь илэрхий тохиолдолд түүний биеийн байдлыг хөнгөвчлөх зорилгоор өвдөлт, зовиур шаналгааг багасган, амар тайван байдлыг хангахад эмчилгээ, үйлчилгээг чиглүүлж болно.

Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудсан болон нас барсан талаар мэдээлэх

- 6.12 Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдал эрс муудсан буюу үйлчлүүлэгч нас барсан тохиолдолд энэ талаар түүний хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран

хамгаалагч, харгалзан дэмжигч)-д үнэн бодитоор мэдээлэх үүргийг зөвхөн эмч хүлээнэ.

Эмч солих

6.13 Үйлчлүүлэгчид урьдчилан мэдээлж, зөвшөөрөл авалгүйгээр төлөвлөгөөт мэс заслын явцад эмчийг сольж болохгүй.

Хүчирхийлэл

6.14 Эмнэлгийн мэргэжилтэн нь өөрийн үйлчлүүлэгчид хүчирхийллийн (бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны г.м) шинж тэмдэг байгаа эсэхийг байнга анхаарч, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдээлж, таслан зогсоох, давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллана. Хүчирхийлэлд өртөх эрсдэл бүхий хүмүүстэй ажилладаг эмнэлгийн мэргэжилтнүүд хүчирхийллийг илрүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдэнтэй харилцах талаар мэдлэгтэй байвал зохино.

ДОЛОО. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага

7.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гаргасан нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон, Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны болон салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтнүүдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2 Ёс зүйн хорооноос хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжуудад зааснаар зохицуулна.

Үйлчлүүлэгч нь:

- ✓ Монгол улсын Үндсэн хуулийн 14.2-т зааснаас гадна эрүүл мэндийн байдал, бэлгийн сонирхол, өвчний онцлог байдал болон хувийн зан төлвөөс үл хамааран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй авах;
- ✓ Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүрэн, бодит мэдээллийг өөрөө асуугаагүй тохиолдолд ч ойлгомжтой үг хэллэгээр авах;
- ✓ Эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаварын талаар эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцах, тайлбар авах;
- ✓ Нууцаа хамгаалуулах. үйлчлүүлэх явцад эмнэлгийн мэргэжилтэнд өгсөн хувийн мэдээллийн нууц нь үйлчлүүлэгч өөрөө зөвшөөрсөн эсвэл хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд задрахгүй байх баталгаагаар хангагдах;
- ✓ Эмнэлэг болон эмчийг өөрөө сонгох, тусламж үйлчилгээг хүлээн авах явцад эмчийг солих санал тавих;

- ✓ Эмчийн зөвлөсөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эсэхийг өөрөө шийдэх, нийгэмд аюултай халдварт өвчтэй, сэтгэцийн хувьд өөрийгөө хянах чадваргүй болсноос бусад тохиолдолд эмчийн санал болгосон аливаа оношлогоо, эмчилгээг хийлгэхээс татгалзах;
- ✓ Хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний талаар холбогдох байгууллагад мэдээлэх, өргөдөл, гомдол гаргах;
- ✓ Нарийн мэргэжлийн болон ижил мэргэжлийн бусад эмчид үзүүлэх талаар эмчлэгч эмчид хүсэлт тавих;
- ✓ Анагаах болон шинжлэх ухааны туршилтад оролцохоос татгалзах бололцоогоор хангагдана.

Үйлчлүүлэгчийн баримтлах зарчим

- ✓ Өөрийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- ✓ Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд, үйлчлүүлэгчийг хүндэтгэн харилцаж, соёлтой үйлчлүүлэх;
- ✓ Тусламж, үйлчилгээ авч буй эмнэлгийн байгууллагын дотоод журмыг чанд биелүүлэх;
- ✓ Өөрийн эрүүл мэндийн талаар эмнэлгийн мэргэжилтэнд шаардлагатай мэдээллийг үнэн зөв, бүрэн өгөх;
- ✓ Эмчилгээний заавар, дэглэмийг чанд сахих ба ийнхүү сахиж биелүүлэхэд бэрхшээл учирвал холбогдох эмнэлгийн мэргэжилтнүүдэд мэдээлж, учрыг тайлбарлах;
- ✓ Эмчилгээний заавар, дэглэмийг баримтлахаас татгалзсан бол гарч болох сөрөг үр дагавар, хүндрэлийн хариуцлагыг өөрөө хүлээх тухайгаа бичгээр баталгаажуулах;
- ✓ Хууль, дүрмээр зөвшөөрөгдсөн төлбөртэй тусламж үйлчилгээ авсан бол үйлчилгээний төлбөрийг төлөх;
- ✓ Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих болон нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хийгдэж буй нийтийг хамарсан үйл ажиллагаанд иргэнийхээ хувьд идэвхитэй оролцох.

Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү дүрмээр ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Хорооны зорилго нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг мөрдүүлж, хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.
- 1.3 Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хороо /цаашид Хороо гэх/ нь Эрүүл мэндийн сайдын шийдвэрээр байгуулагдах эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлаар санал дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага юм.
- 1.4 Хорооны үйл ажиллагаа нь Монгол улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд болон энэхүү дүрмийн хүрээнд явагдана.
- 1.5 Хороо нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хамгаалах, хараат бус байх зарчмуудыг баримтлана.
- 1.6 Хороо нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах дээд шатны байгууллага бөгөөд төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дэргэд ёс зүйн салбар хороодтой байна.
- 1.7 Хорооны шийдвэрийг эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэн бүр дагаж биелүүлнэ.
- 1.8 Хороо нь тогтсон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Хорооны эрх, үүрэг

- 2.1. Хороо нь дараахь эрхийг эдэлнэ:
 - 2.1.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, хороо, салбар хороодын бүтэц, зохион байгуулалт, ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, Эрүүл мэндийн сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэх;
 - 2.1.2 Шаардлагатай бичиг баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтан, гомдол гаргагч иргэдээс гаргуулан авах, тэдний тайлбарыг сонсох;

- 2.1.3 Эмнэлгийн мэргэжилтнийг буруугүй гэж үзвэл тэдний эрх ашиг, нэр хүндийг хамгаалах, нэр хүндийг нь сэргээх;
- 2.1.4 Ёс зүйн хэм хэмжээг зөрчигсдөд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль журмын дагуу зохих хариуцлага хүлээлгэх;
- 2.1.5 Ёс зүйн хорооны шийдвэрийг биелүүлээгүй буюу зөрчсөн хүмүүст хариуцлага хүлээлгэх тухай саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавих.

2.2. Ёс зүйн хороо нь дараахь үүргийг хүлээнэ:

- 2.2.1. Салбар хороодын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.2.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг нягтлан хүлээн авах, судалж хэлэлцэн, шийдвэрлэх;
- 2.2.3. Салбар хорооны гаргасан шийдвэртэй холбоотой давж заалдсан өргөдөл, гомдлыг хүлээн авч, судалж, хэлэлцэн, шийдвэрлэх;
- 2.2.4. Ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө, чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх;
- 2.2.5. Хорооны шийдвэрийг мэдээлэх, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 2.2.6. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зөрчилтэй холбоотой мэдээллийн сан бий болгож; хөтлөх

Гурав. Хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 3.1 Хороо нь хамтын удирдлагын байгууллага бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал мөн.
- 3.2 Хорооны хурлыг сард 1-ээс доошгүй удаа хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд хорооны даргын шийдвэрээр, эсвэл гишүүдийн олонхийн саналаар зарлан хуралдуулна. Ёс зүйн хорооны гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хурлыг хүчинтэйд тооцно.
- 3.3 Хорооны гишүүн нь хэлэлцэж буй асуудлын талаар ашиг сонирхолын зөрчилдөөнтэй бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзах буюу бусад гишүүдийг энэ шалтгаанаар татгалзан гаргана.
- 3.4 Хуралд Хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцож, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Татгалзсан санал өгсөн гишүүд, тэдний татгалзсан үндэслэлийг хурлын тэмдэглэлд нарийвчлан тусгана.

- 3.5 Хорооны дарга нь ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь ЭМЯ-ны эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.
- 3.6 Хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил үүргийн хуваарийг Хорооны хурлаар хэлэлцэн батална.
- 3.7 Хороо нь хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, ёс зүйн хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.8 Хорооны хурлын шийдвэрийг санал, өргөдөл, гомдол гаргагч, хариуцлага хүлээгч болон холбогдох байгууллагад бичгээр хүргүүлнэ.
- 3.9 Хорооны даргын эзгүйд түүний үүргийг орлогч дарга түр орлон гүйцэтгэнэ.
- 3.10 Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 3.11 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой зарим өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох салбар хороодод шилжүүлэн шийдвэрлүүлж болно.
- 3.12 Хороо нь Байнгын гишүүд болон бие даасан зөвлөх-гишүүдтэй байна. Байнгын гишүүд нь Хорооны хуралд тогтмол оролцох; бие даасан зөвлөх-гишүүд нь тухайн мэргэжилтэй холбоотой асуудал хэлэлцэх үед таслах эрхтэй оролцоно.
- 3.13 Хорооны орлогч дарга, байнгын гишүүд, бие даасан зөвлөх-гишүүдийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар 3 жилийн хугацаатай томилно.
- 3.14 Хороо үйл ажиллагаагаа жил бүр Эрүүл мэндийн сайдад тайлагнана.
- 3.15 Хорооны дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.15.1 Хорооны болон салбар хороодын үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар ханган, зохицуулах;
 - 3.15.2 Хорооны хурлыг даргалах;
 - 3.15.3 Хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах;
 - 3.15.4 Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавих;
 - 3.15.5 Дотоод, гадаадад Хороог төлөөлөх;
- 3.16 Хорооны нарийн бичгийн дарга нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.16.1 Хорооноос гарсан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
 - 3.16.2 Хорооны хурлын бэлтгэлийг хангах, товыг зарлах;
 - 3.16.3 Хурлын тэмдэглэл хөтлөх;
 - 3.16.4 Хурлаас гарсан шийдвэрийг санал, өргөдөл, гомдол гаргагч болон хариуцлага хүлээгч, холбогдох байгууллагуудад бичгээр хүргүүлэх;
 - 3.16.5 Салбар хороодын үйл ажиллагааг арга зүйн дэмжлэгээр хангах;
 - 3.16.6 Хорооны үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл боловсруулах;
 - 3.16.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлыг бүртгэж, мэдээллийн сан бий болгох;
- 3.17 Хороо нь дараах шаардлагыг үндэслэн гишүүнийг сонгоно:

- 3.17.1 Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан;
- 3.17.2 Ёсзүйн зөрчилд холбогдож байгаагүй;
- 3.17.3 Ёсзүйн талаар суурь мэдлэгтэй буюу сургалтанд хамрагдах боломжтой;
- 3.17.4 Энэ чиглэлээр ажиллах сонирхолтой;

3.18 Хорооны ажиллах дотоод журам, хурлын дэгийг Хороо тогтооно.

Дөрөв. Хорооны зардал, урамшуулал

- 4.1 Хорооны үйл ажиллагааны зардлыг ЭМЯ-ны төсвөөс санхүүжүүлнэ. Жил тутмын үйл ажиллагааны болон гишүүдийн урамшууллын зардлын төсвийг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга батална.
- 4.2 Хорооны гишүүдэд хурлын ирцийг харгалзан урамшуулал олгоно.
- 4.3 Хорооны үйл ажиллагааны болон гишүүдийн урамшуулалд зориулан гаргах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулах эрхийг Хорооны дарга эдэлж, зарцуулалтыг Эрүүл мэндийн Сайдад тайлагнана.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үлгэрчилсэн журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо /цаашид салбар хороо гэх/ нь орон нутаг, байгууллагын түвшинд эмнэлгийн мэргэжилтний болон биоанагаах ухааны ёс зүйн асуудлаар зөвлөмж, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага юм.
- 1.2 Хорооны зорилго нь үйлчлүүлэгч, эмнэлгийн байгууллага, мэргэжилтний нэр хүнд, эрх ашгийг хамгаалах, хүн амд үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.
- 1.3 Салбар хорооны гишүүд нь Хорооны үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг баримтлан ажиллана.
- 1.4 Салбар хороо нь үйл ажиллагаагаа Монгол улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн холбогдох хуулиуд, Ёс зүйн хэм хэмжээ, Хорооны дүрэм тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд болон энэхүү журмын дагуу явуулна.
- 1.5 Салбар хороо нь тогтсон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Салбар хорооны эрх, үүрэг

- 2.1 Салбар хороо нь дараахь эрхийг эдэлнэ:
 - 2.1.1 Эмнэлгийн мэргэжилтнийг буруугүй гэж үзвэл тэдний эрх ашиг, нэр хүндийг хамгаалах
 - 2.1.2 Шаардагдах бичиг баримтыг холбогдох байгууллага, албан тушаалтан, гомдол гаргагч иргэдээс гаргуулан авах, тэдний тайлбарыг сонсох;
 - 2.1.3 Ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн эсэх нь шалгагдаж буй эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Хороогоор дамжуулан эрх бүхий албан тушаалтнаар шийдвэрлүүлэх;
 - 2.1.4 Ёс зүйн хэм хэмжээг болон Салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй буюу зөрчсөн мэргэжилтнүүдэд хууль журмын дагуу хариуцлага хүлээлгэх тухай саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавих. Үүнд:
 - 2.1.4.1 Сануулах;
 - 2.1.4.2 Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах үүрэг өгөх;
 - 2.1.4.3 Цалингийн хувиар торгох;

- 2.1.4.4 Мэргэжлийн болон эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээний шалгалт дахин өгүүлэх;
 - 2.1.4.5 Үүрэгт ажлаас тодорхой хугацаагаар чөлөөлж, холбогдох эрхзүйн баримт бичгийг судлуулах;
 - 2.1.4.6 Албан тушаалыг өөрчлөх;
 - 2.1.4.7 Хөдөлмөрийн гэрээг цуцлах талаар санал оруулах;
- 2.1.5 Ёс зүйн хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хороонд уламжлах;

2.2. Салбар хороо нь дараахь үүргийг хүлээнэ:

- 2.2.1 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг орон нутаг, байгууллагын хэмжээнд мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- 2.2.2 Ёс зүйн хэм хэмжээний талаар сургалт, сурталчилгааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;
- 2.2.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг судалж, хэлэлцэн, өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх;
- 2.2.4 Өөрийн эрх мэдлийн хүрээнээс давсан буюу шийдвэр маргаантай тохиолдолд Хороонд уламжлан шийдвэрлүүлэх;
- 2.2.5 Хороо, Салбар хорооны шийдвэрийг орон нутаг, байгууллагын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
- 2.2.6 Хороо, Салбар хорооны шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих;
- 2.2.7 Илэрсэн зөрчил доголдлыг арилгах, багасгах талаар арга хэмжээ авах;
- 2.2.8 Үйл ажиллагаагаа жил бүр Хороонд тайлагнах.

Гурав. Салбар хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 3.1 Салбар хороо нь 5 буюу 7 гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг бүх ажилчдын хурлаар сонгож, байгууллагын дарга томилно.
- 3.2 Салбар хороо ажиллаж буй байгууллагын дарга нь салбар хорооны даргын үүргийг, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн хорооны нарийн бичгийн даргын үүргийг тус тус гүйцэтгэнэ.
- 3.3 Хуралд зөвлөх гишүүдийг оролцуулж болно. Зөвлөх нь мэргэжлийн нийгэмлэгийн төлөөлөл байна.
- 3.4 Салбар хорооны хурлыг сард 1 удаа хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд салбар хорооны даргын шийдвэрээр эсвэл гишүүдийн олонхийн саналаар

зарлан хуралдуулна. Гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хурлыг хүчинтэйд тооцно.

- 3.5 Салбар хорооны гишүүн нь хэлэлцэж буй асуудлын талаар ашиг сонирхолын зөрчилдөөнтэй бол тухайн асуудлыг хэлэлцэхэд оролцохоос татгалзах буюу бусад гишүүдийг энэ шалтгаанаар татгалзан гаргана.
- 3.6 Салбар хорооны хуралд хорооны нарийн бичгийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцож, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Татгалзсан санал өгсөн гишүүд, тэдний татгалзсан үндэслэлийг хурлын тэмдэглэлд нарийвчлан тусгана.
- 3.7 Салбар хороо нь хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргаж, Салбар хорооны дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.8 Салбар хорооны хурлын шийдвэрийг эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн ажилтнууд дагаж биелүүлнэ.
- 3.9 Салбар хороо нь өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Дөрөв. Салбар хорооны зардал, урамшуулал

- 4.4 Салбар хорооны үйл ажиллагааны зардлыг аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, байгууллагын төсвөөс санхүүжүүлнэ. Төсвийг аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, байгууллагын дарга батална.
- 4.5 Салбар хорооны гишүүдэд хурлын ирцийг харгалзан урамшуулал олгоно.
- 4.6 Салбар хорооны үйл ажиллагааны болон гишүүдийн урамшуулалд зориулан гаргах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулах эрхийг Салбар хорооны дарга эдэлж, зарцуулалтыг Салбар хороо, аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, байгууллагад тайлагнана.

Ёсзүйн салбар хорооны үлгэрчилсэн бүрэлдэхүүн /хавсралт/

Хорооны бүрэлдэхүүнд орж болох гишүүдэд:

Чанарын менежер (1)

Эмч нарын төлөөлөл (1)

Сувилагч нарын төлөөлөл (1)

Хуулийн мэргэжилтэн эсвэл нийгмийн ажилтан(1)

Мэргэжлийн нийгэмлэгийн төлөөлөл (1)

**МЭС ЗАСАЛ/ МЭС АЖИЛБАР ХИЙЛГЭХ
ТУХАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС**

(Өвчтөний түүх/иргэний эрүүл мэндийн дэвтэрт хавсаргана)

А/ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын нэр:

.....
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын үр дүн (эмнэл зүйн туршлагын дүн, нотолгоонд тулгуурлан бүрэн эдгэрэлт, сайжралт, эндэгдэл, хүндрэлийн магадлалыг хувиар илэрхийлэн ойлгомжтойгоор тайлбарлана):

.....
.....
.....

Гарч болох эрсдлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Гарч болох хүндрэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Тухайн мэс засал/мэс ажилбарын үед хийгдэж болох нэмэлт ажилбаруудыг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Тухайн мэс засал/мэс ажилбарыг орлуулж болох эмчилгээний бусад аргуудыг дурьдана:

.....
.....
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын давуу тал:

.....
.....
.....

Санал болгож буй мэс засал/мэс ажилбарын үед хийгдэх мэдээгүйжүүлэлт:

- Ерөнхий Нугасны мэдээ алдуулалт
 Хэсгийн мэдээ алдуулалт Тайвшруулах

Үйлчлүүлэгчээс тавьсан асуулт:

.....
.....
.....

Дээрхи асуултын хариулт (товч):

.....
.....
.....

Эмчтэй холбоо барих утас:

Би үйлчлүүлэгчдээ дээрхи мэдээллүүдийг дэлгэрэнгүй, энгийн ойлгомжтой хэллэгээр тайлбарлаж өгсөн болно.

Эмчийн гарын үсэг _____ / _____ /
нэр

огноо: _____ он _____ сар _____
Б/ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ:

Эмчийн санал болгож буй мэс засал/ мэс ажилбарыг дээрхи мэдээ алдуулалтын дор хийлгэхийг **БИ ЗӨВШӨӨРЧ БАЙНА.**

Түүнчлэн гэмтсэн эд, эрхтнийг журмын дагуу устгахыг уг эмнэлэгт зөвшөөрч байна.

Мэс засал/мэс ажилбарын үр дүн, гарч болох хүндрэл, эрсдэл, нэмэлт ажилбарууд, орлуулж болох эмчилгээний талаар **БИ ТОДОРХОЙ МЭДЭЭЛЭЛ АВСАН БОЛНО.**

Үйлчлүүлэгчийн гарын үсэг _____ / _____ /
огноо: ____ он ____ сар _____ нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг _____ / _____ /
нэр

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх: _____
огноо: ____ он ____ сар _____

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан

Насанд хүрээгүй Ухаангүй
Сэтгэцийн эмгэгтэй Бусад (тайлбарлана уу)

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэрийн хийлгэхээр зөвшөөрсөн мэс заслын хагалгааг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг _____ / _____ /
огноо: ____ он ____ сар _____ нэр

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөргүй бол тайлбарлана уу:

.....
.....
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

**АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД ЭРСДЭЛТЭЙ
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС**

(Өвчтөний түүх/иргэний эрүүл мэндийн дэвтэрт хавсаргана)

А/ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Санал болгож буй оношлогооны ажилбар/эмчилгээ:

.....
.....

Санал болгож буй оношлогооны ажилбар/эмчилгээний үр дүн (эмнэл зүйн туршлагын дүн, нотолгоонд тулгуурлан бүрэн эдгэрэлт, сайжралт, эндэгдэл, хүндрэлийн магадлалыг хувиар илэрхийлэн ойлгомжтойгоор тайлбарлана):

.....
.....
.....

Гарч болох эрсдлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Гарч болох хүндрэлүүдийг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Тухайн оношлогооны ажилбар/эмчилгээний үед хийгдэж болох нэмэлт ажилбаруудыг нэг бүрчлэн дурьдана:

.....
.....
.....

Тухайн оношлогооны ажилбар/эмчилгээг орлуулж болох эмчилгээний бусад аргуудыг дурьдана:

.....
.....
.....

Санал болгож буй оношлогооны ажилбар/эмчилгээний давуу тал:

.....
.....
.....

Санал болгож буй оношлогооны ажилбар/эмчилгээний үед хийгдэж болох мэдээгүйжүүлэлт:

- Ерөнхий
- Нугасны мэдээ алдуулалт
- Хэсгийн мэдээ алдуулалт
- Тайвшруулах

Үйлчлүүлэгчээс тавьсан асуулт:

.....
.....
.....

Дээрхи асуултын хариулт (товч):

.....
.....
.....

Эмчтэй холбоо барих утас:

Би үйлчлүүлэгчдээ дээрхи мэдээллүүдийг дэлгэрэнгүй, энгийн ойлгомжтой хэллэгээр тайлбарлаж өгсөн болно.

Эмчийн гарын үсэг _____ / _____ /
нэр

огноо: ____ он ____ сар ____

Б/ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ:

Надад шаардлагатай оношлогооны ажилбар/эмчилгээ(зурах)-ний талаар
эмчийн өгсөн мэдээллүүдийг **БИ ОЙЛГОСОН.** Иймд

.....
.....
.....

хийлгэхийг **ЗӨВШӨӨРЧ БАЙНА.**

Эмчийн санал болгосон оношлогооны ажилбар/эмчилгээ(зурах)-нээс гадна

.....
.....
.....

зэрэг нэмэлт ажилбар болон орлуулах эмчилгээ нь зөвхөн миний амь насыг аврах болон миний биеийн байдлыг муудахаас сэргийлэхийн тулд хийнэ гэдгийг **БИ ОЙЛГОЖ БАЙНА.**

Харин дараах ажилбаруудыг **ХИЙЛГЭХИЙГ БИ ЗӨВШӨӨРӨХГҮЙ БАЙНА.**

.....
.....
.....

Үйлчлүүлэгчийн гарын үсэг _____ / _____ /
нэр

огноо: ____ он ____ сар ____

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг _____ / _____ /

нэр

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх: _____

огноо: ____ он ____ сар ____

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан

Насанд хүрээгүй Ухаангүй
Сэтгэцийн эмгэгтэй Бусад (тайлбарлана уу)

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэрийн хийлгэхээр зөвшөөрсөн мэс заслын хагалгааг би мөн зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг _____ / _____ /
нэр

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөргүй бол тайлбарлана уу:

.....
.....
.....

огноо: ____ он ____ сар ____

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

**ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР ЭМНЭЛГЭЭС ГАРАХ ТУХАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС**
(Өвчтөний түүхэнд хавсаргана)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ _____ овогтой _____ би эмчийн
зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарах нь эмчлэгч эмч болон эмнэлгийн
удирдлагын зааврыг дагаж мөрдөөгүй гэдгийг ойлгож байна.

Миний эмнэлгээс гарч буй шалтгаан:

.....
.....
.....

Энэ мөчид эмнэлгээс гарснаар миний биед гарч болох хүндрэлүүдийн талаар
дараах **МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН БОЛНО.**

.....
.....
.....

Дээр дурьдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг **БИ ОЙЛГОСОН**
бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг **МЭДЭЖ**
БАЙНА.

Энэ мөчид эмнэлгээс гарч, тусламж үйлчилгээ зогссоноос болж гарах үр
дагаварт эмчлэгч эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг _____ / _____ /
огноо: ____ он ____ сар _____ нэр

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн
гарын үсэг _____ / _____ /
нэр

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх: _____
огноо: ____ он ____ сар _____

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

Насанд хүрээгүй Ухаангүй

Сэтгэцийн эмгэгтэй

Бусад (тайлбарлана уу)

Хэрэв өвчтөн жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэр эмчийн зөвшөөрсөн хугацаанаас өмнө эмнэлгээс гарахыг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг _____ / _____ /
нэр

огноо: ____ он ____ сар ____

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөргүй бол тайлбарлана уу:

.....
.....
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.

**ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ТАТГАЛЗСАН
ТУХАЙ ХУУДАС**

(Өвчтөний түүх/иргэний эрүүл мэндийн дэвтэрт хавсаргана)

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ _____ овогтой _____ би эмнэлгийн тусламж үйлчлэгээнээс татгалзах нь ямар үр дагавартай болох тухай мэдээллийг эмчээсээ авсан боловч уг эмчилгээ үйлчилгээнээс **ТАТГАЛЗАЖ БАЙНА.**

Эмнэлгийн тусламж үйлчлэгээнээс татгалзаж буй шалтгаан:

.....
.....
.....

Эмнэлгийн тусламж үйлчлэгээнээс татгалзснаар миний биед гарч болох хүндрэлүүдийн талаар дараахи **МЭДЭЭЛЛИЙГ БИ АВСАН.**

.....
.....
.....

Дээр дурьдсан хүндрэлийн жагсаалт нь бүрэн бус гэдгийг **БИ ОЙЛГОЖ БАЙГАА** бөгөөд хэрвээ би хүссэн тохиолдолд нэмэлт мэдээлэл авч болно гэдгийг **МЭДЭЖ БАЙНА.**

Эмнэлгийн тусламж үйлчилгээнээс татгалзсанаас гарч болох үр дагаварт эмчлэгч эмч, эмнэлгийг буруутгахгүй.

Үйлчлүүлэгчийн гарын үсэг _____ / _____ /
нэр
огноо: ____ он ____ сар ____

Үйлчлүүлэгч гарын үсэг зурах эрх зүйн чадамжгүй бол:

Асран хамгаалагч/харгалзан дэмжигчийн гарын үсэг _____ / _____ /
нэр

Үйлчлүүлэгчтэй ямар холбоотой эсэх: _____

огноо: ____ он ____ сар ____

Үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй байгаа шалтгаан:

Насанд хүрээгүй
Сэтгэцийн эмгэгтэй

Ухаангүй
Бусад (тайлбарлана уу)

Хэрэв жирэмсэн тохиолдолд;

Миний эхнэр дээрхи эмчилгээ үйлчилгээнээс татгалзсныг би зөвшөөрч байна.

Нөхрийн гарын үсэг _____ / _____ нэр

огноо: ____ он ____ сар ____

Хэрэв асран хамгаалагч/харгалзан дэмжигч/ нөхөр нь зөвшөөргүй бол тайлбарлана уу:

.....
.....
.....

Энэхүү зөвшөөрлийн хуудсыг 2 хувь үйлдсэн болно.